



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

Нэмэлт мэдээлэл авахыг хүсвэл дараах хаягаар харилцана уу:

Санхүүгийн аудитын газрын захирал
бөгөөд Тэргүүлэх аудитор: Ц.Наранчимэг
Утас: 261663
Цахим хаяг:
naranchimegts@audit.gov.mn

Аудитын менежер:
С.Оюунгэрэл
Утас: 261885
Цахим хаяг:
oyungerels@audit.gov.mn

Аудитор:
Ш.Отгонбаяр
Утас: 261740
Цахим хаяг:
otgonbayarsh@audit.gov.mn

ТАБ-ын хаяг: Засгийн газрын IV байр,
Чингэлтэй дүүрэг, бага тойруу-6,
Улаанбаатар – 46, Монгол улс
Цахим хуудас: www.audit.mn

“Монголиан бизнес рейтинг аудит” ХХК
Ерөнхий захирал Д.Түмэнжаргал
Утас: 70005329
Цахим хаяг:
mbr.audit.llc@gmail.com

БОЛОВСРОЛ, СОЁЛ, ШИНЖЛЭХ
УХААН, СПОРТЫН ЯАМНЫ ХАРЪЯА

БОГД ХААНЫ ОРДОН МУЗЕЙН 2017 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН

Аудитын тайлан

2017 оны Санхүүгийн тайлан

Хавсралт 1: Агуулга

Хавсралт 2: Аудитын гэрчилгээ

Хавсралт 3: Менежментийн захидал

Хавсралт 4: Аудит хийсэн санхүүгийн
тайлан

Хавсралт 5: Төсвийн гүйцэтгэлийн
тайлан

01

ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА

ЗӨРЧИЛГҮЙ
САНАЛ ДҮГНЭЛТ

АГУУЛГА

1. Аудит хийх хууль эрх зүйн үндэслэл
2. Байгууллагын хууль, эрх зүйн орчин
3. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа
4. Аудитын шалгуур үзүүлэлт, аудитын арга зүй, хэрэгжүүлсэн горим, хяналтын сорил болон нарийвчилсан горим, түүний үр дүн
5. Дотоод хяналт
6. Төсвийн орлого, зардлын гүйцэтгэл, түүний талаарх тайлбар
7. Шилэн дансны мэдээлэл
8. Олж тогтоосон гол эрсдэлүүд, түүний үр дагавар
9. Гол, онцлог гүйлгээний талаарх (тохиромжтой бол) тайлбар
10. Аудитаар илрүүлсэн гол зөрчлүүд, тэдгээрийг шийдвэрлэсэн талаар:
11. Материаллаг бус залруулагдаагүй алдаануудын талаарх тайлбар:
12. Анхаарал татахуйц бусад чухал асуудал
13. Дараагийн аудитаар авч үзэх асуудлууд
14. Санхүүгийн тайланд хийсэн аудитаар илэрсэн зөрчлийн нэгтгэл
15. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт
16. Зөвлөмж
17. Аудитын дүгнэлт



БОГД ХААНЫ ОРДОН МУЗЕЙН
ЗАХИРАЛ О.МЭНДСАЙХАН ТАНАА

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр
Утас:26-04-37, Факс:62-26-32-30
E-mail: info@audit.gov.mn

2018.02.23 № 06/481
танай _____-ны № _____-т

Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу “Богд хааны ордон музей”-н 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийв.

Зөрчилгүй санал дүгнэлт


“Богд хааны ордон музей”-н 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг материаллаг зүйлсийн хувьд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.

Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар “Богд хааны ордон музей”-н 2017 оны жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайлан дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, програм хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.

Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.



110.10.10.20\Bichig_Khureg\Wawsan_Bichig\2018\02\23\06\06.Docx

070591

Үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч нь Төсвийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1-д заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Нягтлан бодох бүртгэлийн болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, түүнтэй нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН ЗАХИРАЛ
БӨГӨӨД ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР *З. Н*

Ц.НАРАНЧИМЭГ

01

ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА

**ЗӨРЧИЛГҮЙ
САНАЛ ДҮГНЭЛТ**

Нэг. Аудит хийх хууль эрх зүйн үндэслэл:

Монгол Улсын “Төрийн аудитын тухай” хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.5, “Төсвийн тухай” хуулийн 8.9.1-д заасны дагуу “Богд хааны ордон музей” - н 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд /САГ-2018/124/СТА-ТШЗ/ аудит хийлээ.

Аудитыг Төрийн аудитын тухай, Төсвийн тухай, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулиуд болон холбогдох бусад хууль, тогтоомжийн хүрээнд Аудитын олон улсын стандартын зарчмуудад нийцүүлэн төлөвлөлтийн шатанд боловсруулсан төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу явуулав.

Богд хааны ордон музейн 2017 оны санхүүгийн тайлан Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн Олон улсын стандарт /УСНББОУС/, түүнд нийцүүлэн гаргасан улсын төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн захирагч санхүүгийн тайлангаа УСНББОУС, түүнд нийцүүлсэн Сангийн сайдын баталсан холбогдох журмууд, БСШУС-ын сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагад мөрдөгдөх “Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг”, бусад журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Тухайн байгууллагын санхүүгийн тайлан нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, УСНББОУС-тай нийцүүлж материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.


Богд хааны ордон музейн 2017 оны санхүүгийн тайлангийн аудитыг 2018 оны 01 дүгээр сарын 30-ны өдөр анхны уулзалтаа хийж, гэрээт ажлын захидал, аудитын ажилд шаардлагатай материалын жагсаалтыг хүргүүлж аудитыг эхлүүлэн, аудитын төлөвлөлтийн шатанд боловсруулсан төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу 2018 оны 02 дугаар сарын 23-ны өдрийг хүртэлх хугацаанд Монголиан Бизнес Рейтинг Аудит ХХК-ийн аудитын баг хэрэгжүүлэв. /ТАБ-СТА-А-9/

“Монголиан Бизнес Рейтинг Аудит” ХХК нь жилийн эцсийн санхүүгийн тайлангийн аудитыг 2018 оны 01 дүгээр сарын 30-ны өдрөөс 2018 оны 2 дугаар сарын 24-ны хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2018 оны 2 дугаар сарын 25-ны өдөр Богд хааны ордон музейн удирдлагад гардуулна.

Богд хааны ордон музейн 2017 оны төсвийн санхүүгийн тайланг байгууллагын 20 тоот албан бичгээр 2018 оны 2 дугаар сарын 2-нд “Монголиан Бизнес Рейтинг Аудит” ХХК-нд ирүүлсэн бөгөөд Төсвийн тухай хуулинд заасан санхүүгийн тайланг Төрийн аудитын байгууллагад ирүүлэх хугацааг ажлын 6 хоног хэтрүүлсэн зөрчил гаргасан.

Хоёр. Байгууллагын хууль, эрх зүйн орчин:

Богд хааны ордон музей нь Монгол улсын “Соёлын тухай” хууль, “Соёлын өвийг хамгаалах тухай” хууль, “Төрийн болон орон нутгийн өмчийн тухай” хууль, “Төсвийн тухай”, “Нягтлан бодох бүртгэлийн тухай”, “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай”, “Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай”, “Шилэн дансны тухай”, “Нийгмийн даатгалын багц хууль”, “Хөдөлмөрийн тухай хууль”, “Хувь хүний орлогын албан татварын хууль”, “Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай” хуулиудын хүрээнд үйл ажиллагаа явуулж байна. Тайлант онд гол мөрдөгдөж буй хууль,



тогтоомж, түүнд нийцүүлэн гарсан журам, зааварт өөрчлөлт ороогүй байна. Харин Сангийн сайдын 2017 оны 146 дугаар тушаалаар баталсан “Төсвийн зарлагын хэмнэлт, үндсэн үйл ажиллагааны нэмэлт орлогыг зарцуулах, тайлагнах, нягтлан бодох бүртгэлд тусгах, хяналт тавих журам” –ын дагуу тус байгууллагын нэмэлт дансанд 2 удаагийн гүйлгээгээр 98,479.7 мянган төгрөгийн санхүүжилт авч оны эцсээр их хэмжээний нэг удаагийн тэтгэмж урамшуулал, үр дүнгийн урамшууллын зардлыг гаргасан байна.

Гурав. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа

Халхын найман Богдын үйл хэрэг, Монгол буддизмын хөгжил, 20-р зууны эхэн үеийн Үндэсний эрх чөлөөний хувьсгалын түүхтэй холбоотой гэрч болох соёлын өвийг цуглуулах, хадгалан хамгаалах, судлах шинжилж сурталчилах, дэглэн үзүүлэх, сэргээн засварлах, бүртгэн баримтжуулах төв байж, дэлхийн жишигт хүрсэн соёлын үйлчилгээний төв болохын хувьд соёлын биет болон биет бус өвөөр дамжуулж нийгэмд нөлөөлөх байгууллага байхад оршино.

Эрхэм зорилгодоо хүрэх арга замыг хэрэгжүүлэхдээ музейн сэдвийг тодорхойлох судалгааны ажил хийх, материал цуглуулах, мэдээллийн сан бий болгох, өөрийн давтагдашгүй өнгө төрхийг бий болгох, үйлчилгээний чанарыг сайжруулах, сургалт судалгааны төв болгох, түүх соёлын дурсгалт зүйл үзмэрүүдийг олон нийтийн хүртээл болгох, сурталчлах, сэргээн засварлах, сан хөмрөгийн хадгалалт хамгаалалтыг сайжруулах, бүтээгдэхүүний нэр төрлийг олшруулах, орлого нэмэгдүүлэх, гадаад хамтын ажиллагааг өргөжүүлэх үйл ажиллагааны зорилттой ажиллаж байна.

Төсвийн тухай хуулийн 16.5-д заасан бүрэн эрхийн дагуу тус байгууллагын төсвийн шууд захирагч нь батлагдсан төсөв, хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар төсвийн ерөнхийлөн захирагчтай байгуулсан гэрээний хүрээнд төсвийн хөрөнгийг удирдаж, зарцуулалтад нь хяналт тавьж ажилласан байна.

Тус байгууллагын 2017 оны төсвийг БСШУСЯ-ны Төрийн сангийн газраас олгож байна.

Тус байгууллагын үйл ажиллагааны талаар төлөвлөлтийн шатанд ТАБ-СТА-А-1 маягтад тодорхой тусгасан.

Дөрөв. Аудитын шалгуур үзүүлэлт, аудитын арга зүй, хэрэгжүүлсэн горим, хяналтын горим, хяналтын болон нарийвчилсан сорил, түүний үр дүн:

Аудитыг гүйцэтгэхдээ Нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, УСНББОУС, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Шилэн дансны тухай хууль, Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар батлагдсан “Төсөвт байгууллагын санхүүгийн тайланг бэлтгэх заавар”-ын хэрэгжилт, бусад холбогдох заавар журмуудыг шалгуур болгон, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2014 оны 203 дугаар тушаалаар баталсан “Санхүүгийн тайлангийн аудитын журам”, бусад гарын авлагын дагуу гүйцэтгэв.

Аудитаар Богд хааны ордон музейн 2017 оны санхүүгийн тайланд дүгнэлт өгөх үүднээс гүйцэтгэх удирдлагын бэлтгэсэн санхүүгийн тайлан нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд төсвийн дансны уламжлалт болон хяналтын эрсдэлийг тогтоон тухайн байгууллагын зүгээс тавьж буй дотоод хяналтыг үнэлж баримтжууллаа. /ТАБ-СТА-А-5/

Санхүүгийн тайланг бэлтгэн гаргахад баримталсан бодлого, зарчмуудыг үнэлж, зарим гүйлгээ ихтэй томоохон дансуудад түүвэрчилсэн байдлаар аудитын нарийвчилсан горим, сорил 22-ыг гүйцэтгэв. /ТАБ-СТА-В-3/

Тухайн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, нягтлан бодох бүртгэлийн мэдээллийн системтэй танилцахад “Acolous 3.0” программ ашигладаг, БСШУС-ын сайдын 2017 оны А/40 тоот тушаалаар баталсан “Нягтлан бодох бүртгэлийн

бодлогын баримт бичиг"- ийг нягтлан бодох бүртгэлдээ мөрдөн ажиллаж байна. Энэхүү бүртгэлийн бодлогын баримт бичиг нь УСНББОУС-тай нийцсэн байна.

Тус байгууллагын үйл ажиллагаанд ашиглагдаж байгаа компьютерийн системийн үйл ажиллагаатай асуулга явуулах аргаар танилцан түүний нарийн төвөгтэй байдлын үнэлгээг хийхэд бага буюу мэдээллийн технологийн мэргэжилтэнг оролцуулах шаардлагагүй гэсэн үнэлгээ өгч, аудитыг шууд гүйцэтгэлээ. /ТАБ-СТА-В-2/

Богд хааны ордон музейн санхүүгийн үйл ажиллагааг бүртгэх, хянах, боловсруулах үйл ажиллагааг Санхүүгийн тооцоолох ХХК-ийн "Acoulous 3.0" санхүүгийн програмаар боловсруулан, санхүүгийн тайлан бэлтгэх заавар журмын дагуу гаргаж бэлтгэсэн байна.

Материаллаг байдлын түвшин:

Тус байгууллагын 2017 оны 12 дугаар сарын 31-нээр дуусгавар болсон санхүүгийн тайланд тусгагдсан тоон үзүүлэлтүүдээр материаллагийн түвшинд нөлөөлөх хүчин зүйлсийн нөлөөллийг урьдчилан үнэлж, орлого үр дүнгийн тайлангийн урсгал зардал 541,695.8 мянган төгрөгийг материаллаг байдлын суурь болгон түүний 1%-аар тооцож, материаллаг байдлын түвшинг 5,417.0 мянган төгрөгөөр урьдчилан тогтоов. Гүйцэтгэлээр материаллаг байдлыг дахин хянаж, орлого үр дүнгийн тайлангийн нийт зардал 595,824.2 мянган төгрөгөөс 2 хувиар тооцон 11,916.5 мянган төгрөг болгон өөрчлөлт оруулсан болно.

Тав. Дотоод хяналт:

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан. Энэ нь материаллаг алдаа гарахаас хамгаалахын тулд жилийн турш үр нөлөөтэй ажиллах ёстой гол хяналтуудыг тодруулах, судлах зорилготой юм. Тус байгууллагын дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үед "дунд" гэж тооцсон ба дахин хянахад дотоод хяналт хэвийн байна. Гэхдээ дотоод хяналтыг байгууллагын ерөнхий үйл ажиллагаанд хандуулсан чиглэлийг барьж ажилласан байна. Цаашид санхүүгийн чиглэлээр дотоод хяналтыг төлөвлөн гүйцэтгэх шаардлагатай гэж үзлээ.

Зургаа. Төсвийн орлого, зардлын гүйцэтгэл, түүний талаарх тайлбар:

Тус байгууллагын 2017 оны батлагдсан төсвийг сар, улирлын хуваарийн дагуу Төрийн сангийн харилцах дансаар дамжуулан санхүүжүүлсэн байна. Төрийн сангийн газраас тус байгууллагын төсвийн хүрээний мэдэгдлийг боловсруулах, төсвийн санхүүжилтийн гүйцэтгэлийг хангах, төсвийг зардлын хөтөлбөр, зориулалт, ангилалын дагуу хуваарилан баталж, гүйцэтгэлд хяналт тавин ажилласан байна.

Богд хааны ордон музейд 2017 онд анх 356,316.6 мянган төгрөгийн төсөв батлагдсан. Төсвийн тодотголоор 14,949.5 мянган төгрөгийн урсгал төсвийн санхүүжилт нэмэгдэж нийт 371,266.1 мянган төгрөгийн төсөвтэй болсон байна.

Санхүүжилтийн эх үүсвэрийн хувьд улсын төсвийн санхүүжилт 183,018.0 мянган төгрөг, төсөвт байгууллагын үндсэн үйл ажиллагааны 183,248.1 мянган төгрөгийн орлого, туслах үйл ажиллагааны 5000,0 мянган төгрөгийн орлого олох төлөвлөгөө батлагдсан байна.

Санхүүжилийн орлогын гүйцэтгэлийн хувьд улсын төсвөөс урсгал санхүүжилтээ бүрэн авсан, үндсэн болон туслах үйл ажиллагааны орлогыг 14,509.3 мянган төгрөгөөр давуулан 202,757.4 мянган төгрөгийн орлого олсон байна.

Төсвийн зардлын хувьд бараа үйлчилгээний зардалд 362,920.6 мянган төгрөг, урсгал шилжүүлэгт 8,345.5 мянган төгрөгийн төсөв батлагдаж, гүйцэтгэлээр бараа ажил үйлчилгээний зардалд 352,169.0 мянган төгрөг, урсгал шилжүүлэгийн зардалд 8,345.4 мянган төгрөгийг зарцуулан, батлагдсан төсвийг 10,751.6 мянган төгрөгөөр хэмнэсэн байна.

Долоо. Шилэн дансны мэдээлэл

Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг тус байгууллагын вебсайт хуудсанд байршуулсан шилэн дансны мэдээллээс зарим мэдээллийг сонгон авч шалгахад дараах байдалтай байна. Үүнд:

“Бусад мэдээлэл” гэсэн талбарт 6 төрлийн мэдээллийг байршуулах ёстой бөгөөд аудитаар 4 төрлийн мэдээллийг хангалтгүй мэдээлсэн зөрчил илэрлээ.

- Тус байгууллагын захирал нь Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 8, 9 дүгээр зүйлд заасан ашиг сонирхлын мэдэгдэлийг гэрээ хэлцэл байгуулах, төсвийн хөрөнгө захиран зарцуулах тушаал шийдвэр гаргах бүрдээ 7 хоногийн дотор байршуулах ёстой бөгөөд хэрэгжилтийг шалгахад огт мэдээлээгүй байна.
- Тус байгууллагын захирал нь “Бонд, зээл, өрийн бичиг, баталгаа, түүнтэй адилтгах санхүүгийн бусад хэрэгсэл, төр хувийн хэвшлийн түншлэлийн гэрээ, концесс, **төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах**, өр, авлага үүсгэсэн аливаа тушаал, шийдвэрийг гаргах бүрдээ 7 хоногийн дотор байршуулах ёстой бөгөөд хэрэгжилтийг шалгахад 21 удаагийн 196,589.5 мянган төгрөгийн хөрөнгө зарцуулах тухай тушаал шийдвэрийг 2017 онд гаргасан боловч зөвхөн 3 удаагийн 13,472.0 мянган төгрөгийн тушаалыг нийтэд байршуулж мэдээлсэн байна.
- Аудитын тайлан, дүгнэлт, зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний тайланг бүтэн жилээр нэг удаа Шилэн дансанд байршуулах ёстой боловч “Байхгүй” гэж тайлагнасан, тус байгууллагын 2016 оны санхүүгийн тайлангийн аудитаар 2 зөвлөмж өгсөн байтал олон нийтэд зөвлөмжийн биелэлтийг тайлагнаагүй байна.
- Тухайн байгууллагын хууль тогтоомжийн дагуу төвлөрүүлэх төлбөр, хураамж, зохицуулалтын үйлчилгээний хөлсний хэмжээнд орсон өөрчлөлтийг тухай бүр нь Шилэн дансанд байршуулах ёстой бөгөөд хэрэгжилтийг шалгахад Захирлын 2017 оны 7 дугаар сарын 20-ны А/40 тоот тушаалаар Үйлчилгээний жишиг үнийг шинэчлэн тогтоох тухай шийдвэрийг гаргасан боловч Шилэн дансанд нийтэд мэдээлээгүй байна. Байгууллагын үйлчилгээний хураамж төлбөрийг өөрчлөх эрх тус байгууллагын захиралд олгогдсон эсэхийг хянах шаардлагатай.


Найм. Олж тогтоосон гол эрсдэлүүд, түүний үр дагавар:

Аудитын төлөвлөгөөний дагуу аудитын 22 эрсдлийг тогтоож, батламж мэдэгдлүүдийн хүрээнд данс бүрээр нийт 22 нарийвчилсан горим, сорил гүйцэтгэв.

Ажилчдад олгосон нэг удаагийн тэтгэмж урамшууллаас ХХОАТ суутгаагүй, ажил дүгнэсэн нотлох баримт байхгүйгээр ажлын үр дүнгийн урамшуулал, үр чадварын нэмэгдэл олгосон, үзвэр үйлчилгээний орлогыг журмын дагуу харилцах дансанд төвлөрүүлээгүй буюу өмнөх оны зөвлөмжийн биелэлтийг хангаж ажлаагүй, мөнгөн гүйлгээний тайланд биет ба биет бус хөрөнгө бэлтгэсэн 42,419.6 мянган төгрөгийг илчилж тайлагнаагүй, ажилчдад олгох цалингийн өглөгийг тайлант онд хэрэгжүүлэхдээ өмнөх оны үр дүнрүү хаасан, музейн католог, зурагт хуудасны өртөгөөс илүү нэмэлт орлогыг бараа материалын олзоор бүртгэсэн зэрэг зөрчлүүд нь санхүүгийн тайлангийн иж бүрэн байх, хэмжилт, үнэн зөв байдал гэсэн батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

Ес. Гол, онцлог гүйлгээний талаарх (тохиромжтой бол) тайлбар:

Сангийн сайдын 2017 оны 6 дугаар сарын 22-ны өдрийн 216 дугаар тушаалаар “Төсвийн зарлагын хэмнэлт, үндсэн үйл ажиллагааны нэмэлт орлогыг зарцуулах, тайлагнах, нягтлан бодох бүртгэлд тусгах, хяналт тавих журам” батлагдсан. Энэхүү журмаар төсвийн байгууллагууд тайлант жилийн төсвийн зарлагын хэмнэлт, үйл ажиллагааны орлогын давсан орлогыг урамшуулал хэлбэрээр дараа жилдээ зарцуулах эрх олгогддог байсныг тухайн жилдээ эхний хагас, сүүлийн хагас жилдээ 2 удаа зарцуулах болсон тул тус байгууллагын хувьд оны эцэст 2 удаагийн эрхээр 98,479.7 мянган төгрөгийн нэмэлт орлогын санхүүжилтийг авсан. Оны эцсээр их хэмжээний



нэмэлт санхүүжилт авсан тул түүнийг зарцуулахдаа цаг хугацааны хувьд хязгаарлалтанд орж холбогдох журам зааврыг хэрэгжүүлээгүй зөрчил гаргасан байна.

Тус байгууллагын үндсэн болон туслах үйл ажиллагааны орлогын төлөвлөгөөний гүйцэтгэлийг өнгөрсөн 2 оноор авч үзэхэд орлогын төлөвлөгөөг 2016 онд 45 хувиар, 2017 онд 2.2 дахин давуулан биелүүлсэн байна. Үүнээс үзэхэд орлогын төлөвлөлтийг үндэслэлгүй төлөвлөж байгааг цаашид Сангийн яам, БСШУСЯам анхаарах шаардлагатай байна.

*Богд хааны ордоны музейн 2016-2017 оны орлогын төлөвлөгөөний гүйцэтгэл
/мянган төгрөгөөр/*

№	Орлогын нэр төрөл	2016		Биелэлт хувиар	2017		Биелэлт хувиар
		Төлөвлөгөө	Гүйцэтгэл		Төлөвлөгөө	Гүйцэтгэл	
1	Үндсэн үйл ажиллагааны	175,761.4	243,780.6	139%	183,248.1	291,257.3	159%
2	Туслах үйл ажиллагааны	5,000.0	18,812.8	376%	5,000.0	120,437.4	2409%
		180,761.4	262,593.4	145%	188,248.1	411,694.6	219%

Үндсэн хөрөнгийн хөдлөл, өөрчлөлт, түүний тооллогын тухайд:

Үндсэн хөрөнгийн тухайд тайлант онд үндсэн хөрөнгө нийт 181,001.8 мянган төгрөгөөр нэмэгдсэн байна.

Үүнд: Засгийн газрын 2015 оны 408 дугаар тогтоол, Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2016 оны 340 дүгээр тогтоолын дагуу Удирдлагын академийн балансаас балансад шилжүүлэн авсан Богд хаан болон Дондогдулам хатны амьдарч байсан түүхийн дурсгалт 22,123.9 мянган төгрөгийн үнэ бүхий 3 барилга байгууламж, уг барилгуудад БСШУСЯ-ны хөрөнгө оруулалтаар 112,630.8 мянган төгрөгийн, байгууллагын өөрийн хөрөнгөөр 3,995.0 мянган төгрөгийн их засвар хийгдсэн байна.

БСШУСЯ-ны хөрөнгө оруулалтаар 3,389.9 мянган төгрөгийн, урсгал төсөв болон төсвийн урамшууллаас 27,470.6 мянган төгрөгийн нийт 30,860.5 мянган төгрөгөөр тоног төхөөрөмж нэмэгдсэн байна.

Бусад үндсэн хөрөнгийн хувьд төсвийн урамшууллаас 8,646.0 мянган төгрөгийн тавилга хэрэгсэл, 275.0 мянган төгрөгийн биет бус хөрөнгө нэмэгдсэн байна. Номын фонд өөрийн бараа материал данснаас 110.6 мянган төгрөгийн ном шилжүүлсэн, дахин үнэлгээгээр 327.0 мянган төгрөгийн ном, төсвийн урсгал санхүүжилтээр 2,032.4 мянган төгрөгийн ном худалдан авч бэлтгэсэн байна.


Богд хааны ордон музейн үндсэн хөрөнгийн 88.5 хувийг Түүх, соёлын дурсгалт зүйлс эзлэж байна. Иймд түүх, соёлын дурсгалт зүйлсийн хамгаалалт, тооллогод аудитын горим хэрэгжүүлсэн.

БСШУСЯ-ний харьяа Соёлын өвийн үндэсний төв нь Монгол Улсын Сангийн сайд, Боловсрол, Соёл, Шинжлэх ухааны сайд, Мэргэжлийн хяналтын асуудал эрхэлсэн сайдын 2006 оны 09 дүгээр сарын 27-ны өдрийн 299/324/111 тоот хамтарсан тушаалаар “Түүх, соёлын үл хөдлөх дурсгалт зүйл болох булш, хиргисүүр, хадны зураг, бичээс, хөшөө чулуу, сүм хийд, түүний үлдэгдэл, эртний хотын туурь, түүхт овоо суврага зэргийг бүртгэн тоолох” ажлыг 2008 оноос эхлэн хэрэгжүүлж эхэлсэн бөгөөд Богд хааны Ногоон ордон музейн цогцолбор нь улсын хамгаалалтанд байх түүх, соёлын үл хөдлөх дурсгалт объектын бүртгэл, жагсаалтад орсон байна.

Тус музейн дурсгалт зүйлсийн улсын тооллого 2013 онд явагдсан байна. Улсын хэмжээний тооллогын төв комиссоос томилсон салбар комисс тооллогыг зохион байгуулсан байна. Холбогдох хууль, журмын дагуу хагас жил тутам хосгүй үнэт, үнэт, дурсгалт зүйлсийн тооллогын мэдээг Соёлын өвийн үндэсний төвд хүргүүлдэг байна.

Тооллогоор дутагдсан түүхийн дурсгалт зүйлс байхгүй, харин түүхийн соёлын дурсгалт зүйлст бүртгэхгүй зүйлс бүртгэгдсэн тухай тооллогын тэмдэглэл байна.

Энэ онд ХБНГУлсад 5 дугаар сараас 9 дүгээр сар хүртэл зохиогдсон үзэсгэлэнд тус музейн Б.Шаравын зурсан “Ногоон ордон” зураг Соёл урлагын газраас хариуцан



БСШУСЯ-ны хяналт дор Засгийн газрын тогтоолоор хилээр нэвтрүүлэх зөвшөөрөл авч оролцсон байна.

Богд хааны ордон музейн 2017 оны санхүүгийн тайлан материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэдгийг, түүнийг бэлтгэн гаргахад баримталсан бодлого, зарчмуудыг үнэлж, аудитын явцад санхүүгийн тайланд нөлөөлөхүйц хэмжээний мөнгөн хөрөнгө, орлого санхүүжилт, үндсэн хөрөнгө, хөрөнгө оруулалт, цалин, НДШ, зардал, НДШ, ХХОАТ-ын ногдуулалт, төлөлт үлдэгдлийн тооцооллуудыг түүвэрчлэн, нарийвчилсан горим, сорилын аргаар шалгалаа./ТАБ-СТА-В-3/

Эдгээр шалгасан нарийвчилсан сорил нь тус байгууллагын нийт орлогын 100 хувь, мөнгөн хөрөнгийн 100 хувь, авлага, өр төлбөрийн 75 хувь, цалин, НДШ-ийн 75 хувь, нийт зарлагын 75 хувийг тус тус эзэлж байна.

Арав. Аудитаар илрүүлсэн гол зөрчлүүд, тэдгээрийг шийдвэрлэсэн талаар:

Санхүүгийн тайлангийн аудитаар хөндөгдсөн гол асуудлуудыг дараах заалтад хураангуйлан тэмдэглэв. Аудитаар дараах алдаа, зөрчил илэрсэн байна. Үүнд:

1. Мөнгөн гүйлгээний тайланд биет ба биет бус хөрөнгө бэлтгэсэн 42,419.6 мянган төгрөгийн үндсэн хөрөнгө бэлтгэсэн зардлаар илчилж тайлагнаагүй нь Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад мөрдөгдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”, санхүүгийн тайлан, тодруулгын маягтын загвараар толилуулаагүй байна.

Шийдвэрлэсэн нь: МГТайланд толилуулга хийх залруулах бичилт хийсэн

2. Санхүүгийн тайлангийн тодруулгыг батлагдсан маягтын дагуу бэлтгээгүй, илтгэх хуудас бичсэн нь Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалын 2 дугаар хавсралтаар баталсан санхүүгийн тайлан, тодруулгын маягтуудыг хэрэгжүүлж ажлаагүй байна.


Шийдвэрлэсэн нь: Зөрчил арилгуулах албан шаардлага хүргүүлэх

3. Ажилчдад олгох 652.2 мянган төгрөгийн цалингийн өглөгийг тайлант онд барагдуулахдаа 43.8 мянган төгрөгөөр илүү буюу 696.0 мянган төгрөгөөр өмнөх оны үр дүн рүү хаасан нь Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад мөрдөгдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ын дагуу зөв бүртгээгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Өмчийн өөрчлөлтийн тайланд залруулах бичилт хийсэн.

4. Музейн катологи, зурагт хуудсны өртөгөөс илүү үнээр борлуулсаны 2,715.7 мянган төгрөгийн орлогыг бараа материал худалдсаны олзоор бүртгэсэн нь Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад мөрдөгдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ын дагуу зөв бүртгээгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Санхүүгийн үр дүнгийн тайланд залруулах бичилт хийсэн.



5. Тайлант хугацаанд үзвэр, үйлчилгээний 171,068.6 мянган төгрөгийн орлогыг касс тушаасан бөгөөд үүнээс санамсаргүй түүврийн аргаар сорил гүйцэтгэхэд 15,719.8 мянган төгрөгийн орлогыг байгууллагын харилцах дансанд ажлын дараа хоногт багтааж төвлөрүүлээгүй нь Сангийн сайдын 2012 оны 276 дугаар тушаалаар батлагдсан “Төсвийн байгууллагад мөрдөгдөх кассын ажиллагааны журам”- 2.6, 3.12 дахь заалттай нийцээгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар ийм зөрчилд зөвлөмж хүргүүлсэн боловч хэрэгжүүлээгүй байх тул зөрчил арилгуулах албан шаардлага хүргүүлэх.

- Тайлант онд үзвэрийн орлогын 2,002.5 мянган төгрөгийн авлагатай байсан боловч оны эцэст 23 харилцагчаас 13,783.0 мянган төгрөгийн авлагатай тайлагнаж, үзвэр үйлчилгээний орлогын авлага 6.9 дахин өссөн бөгөөд 2017 онд 46 компанитай гэрээ байгуулж үүнээс зөвхөн 4 компанитай тооцоо нийлсэн акт үйлдэн 4,672.0 мянган төгрөгийн авлагыг баталгаажуулсан, 9,111.0 мянган төгрөгийн авлагыг баталгаажуулаагүй нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.3 дахь заалттай нийцээгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Тооцоо нийлсэн акт үйлдэн өглөг авлагыг баталгаажуулж байх зөвлөмж хүргүүлэх

- Байгууллагын үндсэн үйл ажиллагааны орлогын төлөвлөгөөнөөс давсан эхний хагас жилийн орлого 86,496.2 мянган төгрөг, сүүлийн хагас жилийн давсан орлого 11,983.5 мянган төгрөгийг Сангийн сайдын 2017 оны 216 дугаар тушаалаар батлагдсан журмын дагуу зарцуулсан бөгөөд ажиллагсдад олгосон нэг удаагийн тэтгэмж урамшууллын 25,962.5 мянган төгрөгийн орлогыг ажиллагсдад олгохдоо 2,596.2 мянган төгрөгийн ХХОАТ суутгаагүй нь Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн 26.1.2-дэх заалт, Татварын Ерөнхий газрын даргын 2013 оны 509 дугаар тушаалаар батлагдсан “Хувь хүнд олгосон орлогоос суутгал хийн төсөвт шилжүүлэх заавар”-ын 2.1, 2.2-д заасантай нийцээгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төлбөрийн акт тогтоож төсөвт төвлөрүүлэх.

- Нэр бүхий 7 албан хаагчдад оны эхэнд цалин тогтоосон A/01 тоот тушаалаар сард 459.4 мянган төгрөгийн үр чадварын нэмэгдэл олгох шийдвэр гаргасан, тус байгууллагад ажиллагсдын ажлын үр дүнг үнэлэх журам байхгүй, ажлын үр дүнг үнэлсэн үнэлгээ, дүн байхгүй байж үр чадварын нэмэгдэлийг бүтэн жилээр олгосон нь Засгийн газрын 1995 оны 96 тогтоолын 5 дугаар хавсралтаар баталсан “Үр чадварын нэмэгдэл олгох журам”, Хүн амын бодлого, хөдөлмөрийн сайд, сангийн сайдын 1996 оны 63/104 дугаар тушаалаар баталсан “Төрийн үйлчилгээний албаны түгээмэл мэргэжлийн албан хаагчдад үр чадварын нэмэгдэл олгох нийтлэг журам”-тай нийцээгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Ажиллагсдад үр чадварын нэмэгдэл олгохдоо ажлын үр дүнг үнэлж дүгнэж байж олгох тухай албан шаардлага хүргүүлэх

- Тус байгууллагын хувьд ажиллагсдын үр дүнгийн урамшуулал, нэг удаагийн тэтгэмж урамшууллын зардалд 38,233.4 мянган төгрөгийг оны эцсээр 12 дугаар сард 3 удаа тооцон олгосон бөгөөд ажил дүгнэсэн нотлох баримт материал хангалтгүй, үр дүнгийн урамшууллыг ажиллагсдад үндсэн цалинг 1.5 – 9.8 дахин их хэмжээгээр тооцон олгосон нь Засгийн газрын 1995 оны 96 дугаар тогтоолын 6 дугаар хавсралтаар баталсан “Төрийн албан хаагчид шагнал, урамшил олгох журам”-ын 5-д заасан “Төрийн байгууллагын захиргаа нь мэргэжлийн өндөр үр чадвар, идэвх санаачилга гарган албан үүргээ тогтмол чанартай сайн биелүүлж, ажлын өндөр амжилт гаргасан, албаны болон төрийн албан хаагчийн ёс зүйн хэм хэмжээ, төрийн байгууллагын соёл, дэг журмыг сахиж, төрийн байгууллага, албан хаагчийн нэр хүндийг эрхэмлэн дээдэлж, мэдлэг мэргэжлээ байнга дээшлүүлж байгаа төрийн албан хаагчид улирлын ажлын нь үр дүнгээр албан тушаалын сарын цалингийн **40 хүртэл хувьтай тэнцэх хэмжээний мөнгөн шагнал** олгож болно” гэсэн заалтыг зөрчин журманд заасан дээд хэмжээнээс шагналт цалин, урамшуулал тэтгэмжийг илүү олгосон зөрчил илэрсэн.

№	Тушаал, шийдвэрийн		Олгосон нэг удаагийн тэтгэмж урамшууллын хэмжээ
	дугаар	огноо	
1	A/68	12/14/2017	12,271.0
2	A/77	12/19/2017	19,662.5
3	A/83	12/25/2017	6,300.0
			38,233.4

Шийдвэрлэсэн нь: Ажиллагсдын ажлын үр дүнг дүгнэх журам боловсруулан мөрдөж ажиллах, үр дүнгийн урамшуулал олгохдоо ажлыг үнэлж үр дүнг харгалзан олгох тухай зөрчил арилгуулах албан шаардлага хүргүүлэх

Арван нэг. Залруулагдаагүй алдаануудын талаарх тайлбар:

Залруулагдаагүй 66,119.8 мянган төгрөгийн алдаанаас 2,596.2 мянган төгрөгийн алдаанд нөхөн төлбөрийн акт тогтоож, 24,830.8 мянган төгрөгийн алдаанд зөрчил арилгуулах албан шаардлага тавьж, 38,692.8 мянган төгрөгийн алдаанд зөвлөмж хүргүүлсэн болно.

Арван хоёр. Анхаарал татахуйц бусад чухал асуудал:

Богд хааны ордон музей 3.4 га газрыг эзэмшдэг бөгөөд Засгийн газрын 2001 оны 96 дугаар “Хамгаалалтын бүс тогтоох тухай” тогтоолоор тус музейн түүх, соёлын үл хөдлөх дурсгалыг хамгаалах зорилгоор Богд хааны Ногоон ордон хамгаалалтын бүсийг 5.7 га газраар тогтоож “Хамгаалалтын бүсэд түүх, соёлын үл хөдлөх дурсгалт зүйлийн хадгалалт хамгаалалт, бүрэн бүтэн байдалд хохирол учруулахуйц үйл ажиллагаа явуулах, барилга барихгүй байх”-ыг Нийслэлийн Засаг даргад даалгасан байна.


Одоогийн байдлаар тус хамгаалалтын бүсэд Вантрейд ХХК-нд 1.6 га, Номун гэрэл төвд 0.5 га газар олгогдож, Интернейшнл медикал сентер ХХК-ны эзэмшил газарт 0.2 га орсон байна. Тус байгууллагаас хамгаалалтын бүсийн газрыг эзэмших хүсэлтийг холбогдох газарт удаа дараа хүргүүлсэн боловч Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай, Тусгай хамгаалалттай газар нутгийн орчны бүсийн тухай хуулиудад Засгийн газраас тогтоосон “Хамгаалалтын бүс”-ийн талаарх эрх зүйн зохицуулалт байхгүй, тусгай хамгаалалттай газрын ангилалд “Хамгаалалтын бүс” гэсэн нэршил байхгүй шалтгаанаар тухайн газрыг байгууллагын эзэмшилд авч чадалгүй өдий хүрсэн байна.

